



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

90/93 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/953

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын Аялал, жуулчлал хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжих “Говийн бүс нутгийн өв соёл, танин мэдэхүй, түүх оюун санаа язгуурын ай савын судалгаа” хийх зөвлөх үйлчилгээний гэрээг “Чономун” ХХК-тай 20,000,000 (хорин сая) төгрөгөөр байгуулсугай.

2. Гэрээний нөхцлийн дагуу судалгааг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Чономун” ХХК (С.Гансувд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4823100692